

**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**2020 оны 04 сарын 20 өдөрДугаар: A/32


Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Сангийн сайдын 2017 оны 01 дүгээр тушаалаар батлагдсан Үндэсний давхар даатгал ХК-ийн дүрмийн 4.3.2, Гүйцэтгэх захирлын 2019 оны А/23 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 3.1.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний давхар даатгал ХК-ийн “Эрсдэлийн удирдлагын журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. “Эрсдэлийн удирдлагын журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг компанийн нийт ажилтнуудад үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газар /Д.Дуулал/-т үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалыг 2020 оны 4 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Г.ЭНХТАЙВАН

## Нэг. Нийтлэг үндэслэл

- ## Хоёр. Эрсдэлийн удирдлага, ангилал

- 2.1. Эрсдэлийг үүсгэх хүчин зүйлээс хамааруулан дараах байдлаар ангилна.
  - 2.1.1. “Үйл ажиллагааны эрсдэл”-д санхүү, мэдээлэл технологи, хууль эрх зүй, хүний нөөцийн эрсдэл, болзошгүй эрсдэлүүдийг хамааруулан авч үзнэ. Үүнд:
    - 2.1.1.1. Санхүүгийн эрсдэлийн удирдлагад компанийн нягтлан бодох бүртгэлийг хууль, тогтоомж, стандартын дагуу хөтлөх, төсвийг бодитой төлөвлөж, үр ашигтай зарцуулах, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой эрсдэлийг;
    - 2.1.1.2. Эдийн засгийн эрсдэлд эдийн засгийн үзүүлэлтүүдийн төсөөлөл бодит байдал дээр өөрчлөгдөх, зах зээлийн байдал макро болон микро түвшинд муу үр дүн үзүүлэх эрсдэлийг;
    - 2.1.1.3. Оролцогч талуудын эрсдэлд хамтран ажиллагч байгууллагууд болон үйлчлүүлэгчдийн зүгээс учруулж болзошгүй эрсдэлийг;
    - 2.1.1.4. Мэдээлэл технологийн эрсдэлд компанийн программ хангамж, техник тоног төхөөрөмж, мэдээллийн нэгдсэн систем, түүний аюулгүй байдалтай холбоотой үүсэж болох эрсдэлийг;
    - 2.1.1.5. Улс төрийн эрсдэлд улс төрийн тогтворгүй байдлаас шалтгаалан компанийн хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөх байдлыг;
    - 2.1.1.6. Хууль эрх зүйн эрсдэлд хууль, дүрэм журмыг мөрдөн ажиллаагүйгээс эсхүл гэнэтийн зохицуулалт, хууль, тогтоол батлагдсанаас үүдэн байгууллагад учрах эрсдэлийг;
    - 2.1.1.7. Хүний нөөцийн эрсдэлд чадварлаг мэргэжилтний хомсдол, ажлын байрны аюулгүй байдал, ажил үүргийн хариуцлага алдах үйлдлийг;
    - 2.1.1.8. Хөрөнгө оруулалтын эрсдэлд хөрөнгийн хадгалалт, хөрөнгийн үнэ цэнэ буурах, хөрөнгө оруулалтын өгөөж төлөвлөснөөс доогуур байх зэрэг эрсдэлийг;

- 2.1.1.9. Болзошгүй хүчин зүйлийн эрсдэлд цахилгааны хэлбэлзэл, ус алдах, байгалийн гамшигт үзэгдэл, ажлын байрны хэвийн бус байдлаас үүдэн гарах эрсдэлүүдийг;
- 2.1.1.10. Нийгмийн эрсдэлд өвчлөл, гэмт хэрэг, зам тээврийн осол зэрэг эрсдэлүүд нь хувь хүний эрүүл аюулгүй амьдрах, хөдөлмөрлөх боломжид шууд болон шууд бусаар сөргөөр нөлөөлдөг эрсдэлийг;
- 2.1.1.11. Байгалийн гамшгийн эрсдэлд газар хөдлөлт, зуд, үер, ган, ой хээрийн түймэр, хүчтэй салхи, шуурга, хүний гоц халдварт өвчин болон малын гоц халдварт өвчин гарах эрсдэлийг;
- 2.1.2. “Даатгалын эрсдэл”-д хөрвөх чадвар, хүрэлцээтэй байдал, төлбөрийн чадварын эрсдэлүүдийг хамааруулан авч үзнэ. Үүнд:
  - 2.1.2.1. Хөрвөх чадварын эрсдэлд компанийн өөрийн хөрөнгө алдаагүй боловч харилцагчийн өмнө хүлээсэн үүргээ цаг тухайд нь биелүүлэх чадваргүй болох, эсвэл тухайн үүргийг биелүүлэхэд ихээхэн хэмжээний зардал гаргах нөхцөл байдал үүсэхийг;
  - 2.1.2.2. Хүрэлцээтэй байдлын эрсдэл нь даатгалын тохиолдол бий болоход нөхөн төлбөр олгохтой холбоотой үүсэх санхүүгийн эрсдэлийг;
  - 2.1.2.3. Төлбөрийн чадварын эрсдэл нь компанийн хөрөнгө даатгалын гэрээгээр хүлээсэн хариуцлагаа биелүүлэхэд хүрэлцэхгүй болох эрсдэлийг;
- 2.1.3. “Нэр хүндийн эрсдэл” нь компани чиг үүргээ хэрэгжүүлэхэд оролцогч талуудын итгэх итгэл, цаашлаад найдвартай хамтын ажиллагаатай холбоотой үүсэх асуудлыг хэлнэ.
- 2.2. Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа нь компанийн удирдлага, бүх газар, нэгжийг хамарна.
- 2.3. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх хамгаалалтын гурван шугамтай байна.
  - 2.3.1. Хамгаалалтын нэгдүгээр шугам нь газар, нэгжүүд байна. Газар, нэгжүүд нь өөрсдийн эрсдэлийг илрүүлэн, удирдаж энэхүү журмын 3.3, 3.4, 3.5 дугаар зүйлд заасан эрх үүргийг хэрэгжүүлэн ажиллана.
  - 2.3.2. Хамгаалалтын хоёрдугаар шугам нь эрсдэл хариуцсан газар, хэлтэс байна. Эрсдэл хариуцсан газар, хэлтэс нь эрсдэлийг үнэлэн, санал боловсруулж, бусад газар, хэлтсүүдээс хараат бус үйл ажиллагаа явуулах боломжоор хангагдсан байна. Эрсдэлийн удирдлагын журмын 3.6, 3.7 дугаар зүйлд заасан эрх үүргийг хэрэгжүүлэн ажиллана.
  - 2.3.3. Хамгаалалтын гуравдугаар шугам нь дотоод аудит байна. Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хараат бус, бие даасан хяналтыг хэрэгжүүлэн, эрсдэлийн удирдлагын тогтолцоонд үнэлэлт дүгнэлт өгч, ажиллана.

### **Гурав. Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт**

- 3.1. Газар, хэлтсүүд эрсдэлээ илрүүлэх, тайлагнах
  - 3.1.1. Энэхүү журмын 1.3-т заасан аргачлалд үндэслэн эрсдэл хариуцсан газар, нэгжийн заасан хугацаанд 2.1-т заасан эрсдэлээ илрүүлэн (1 дүгээр хавсралтын хоосон мөрүүдэд нэмж бичих), үнэлж, бууруулах, хянах арга хэмжээг тодорхойлон 1 дүгээр хавсралтад заасан загварын дагуу цахимаар хүлээлгэн өгнө.
  - 3.1.2. Гүйцэтгэх захирлын тушаалд үндэслэн компанийн эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, бууруулахтай холбоотой өмнөх жилийн хийсэн ажлын тайланг дараа

- жилийн 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор эрсдэл хариуцсан газар, нэгжид цахимаар хүлээлгэн өгнө.
- 3.2. Эрсдэл хариуцсан газар, нэгж нь газар нэгжүүдээс илрүүлсэн эрсдэлийг үнэлэх, тайлагнах
- 3.2.1. Энэхүү журмын 3.1.1, 3.1.2-т заасны дагуу илрүүлсэн эрсдэл, түүний үнэлгээг дахин шалгах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд газар дээрх болон зайны хяналт шалгалт хийнэ.
- 3.2.2. Энэхүү журмын 3.1.1, 3.2.1-т заасан үнэлгээний үр дүн, эрсдэлийг удирдан бууруулах арга замыг тодорхойлсон санал, газар, нэгжээс ирүүлсэн тайланг жил бүрийн эхний 3 дахь долоо хоногт дотоод хяналтын ажилтан болон Гүйцэтгэх захиралд танилцуулна.
- 3.3. Газар, нэгжийн удирдлагууд нь ажилтнуудын илрүүлсэн эрсдэл, Гүйцэтгэх захирлын гаргасан тушаалын биелэлт, тайлан мэдээлэлд явцын хяналтыг тогтмол хийж ажиллана.
- 3.4. Газар, нэгжүүд нь дараах үүргийг хэрэгжүүлэн ажиллана.
- 3.4.1. Гүйцэтгэх захирлын тушаалыг дагаж мөрдөнө.
- 3.4.2. Эрсдэлийн бүртгэл, тайланг заасан хугацаанд тогтмол гаргаж өгнө.
- 3.4.3. Эрсдэл хариуцсан газар, нэгж газар дээрх болон зайны хяналт хийхэд шаардлагатай нэмэлт мэдээллийг нэмэлт загварын дагуу, үнэн зөв гаргаж өгнө.
- 3.4.4. Холбогдох мэргэжилтэн компанид учрах бодит хохирлын хэмжээ өндөр эрсдэл үүссэн үед газар, нэгжийн удирдлага эрсдэл хариуцсан газар, нэгжид эрсдэлийн нөхцөлд хийсэн шинжилгээний хамт мэдэгдэнэ.
- 3.4.5. Энэхүү журмын 3.1.1-т тодорхойлсон эрсдэлийг бууруулах, хянах арга хэмжээг тухайн газар, нэгжүүд хэрэгжүүлэн ажиллана.
- 3.5. Газар, нэгжүүд нь дараах эрхтэйгээр ажиллана.
- 3.5.1. Эрсдэл хариуцсан газар, нэгжээс эрсдэлийг илрүүлэхтэй холбоотой асуудалд зөвлөгөө авч болно.
- 3.6. Эрсдэл хариуцсан газар, нэгж нь дараах үүргийг хэрэгжүүлэн ажиллана.
- 3.6.1. Гүйцэтгэх захирлаас гарсан тушаалыг 7 хоногийн дотор нийт ажилтнуудад цахимаар хүргүүлнэ.
- 3.6.2. Гүйцэтгэх захирлыг эрсдэлийг удирдахтай холбоотой шаардлагатай, үнэн зөв мэдээллээр хангана.
- 3.6.3. Газар, нэгжүүдийн 3.4.4-т заасан нэн даруй шийдвэрлэх эрсдэлтэй асуудлыг баримтад үндэслэн Гүйцэтгэх захиралд танилцуулна.
- 3.7. Эрсдэл хариуцсан газар, нэгж нь дараах эрхтэйгээр ажиллана.
- 3.7.1. Газар, нэгжүүдээс нэмэлт мэдээллийг нэмэлт загварын дагуу гаргуулан авна.
- 3.7.2. Гүйцэтгэх захирлын тушаалын биелэлтэд хяналт тавьж, тайлагнана.

#### **Дөрөв. Эрсдэлийг удирдах, хяналт тавих**

- 4.1. Гүйцэтгэх захирал нь энэхүү журмын 3.2.3-т үндэслэн 7 хоногийн дотор эрсдэлийг удирдан бууруулах тушаалыг гарган, газар, нэгжүүдэд үүрэг өгнө.
- 4.2. Газар, нэгжүүд тушаалд үндэслэн холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэнэ.
- 4.3. Энэхүү журмын хэрэгжилтэд эрсдэл хариуцсан газар, нэгж хяналт тавьж ажиллана.
- 4.4. Удирдлагууд, ажилтнууд аливаа эрсдэл, эрсдэлтэй үйлдэл, нөхцөлийн талаар холбогдох газар, нэгжид мэдээлэхгүй байх, нуун дарагдуулахыг хориглоно.
- 4.5. Энэ журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтанд байгууллагын дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**Давхар даатгагчийн эрсдэлийн ангилал болон тодорхойлолт**

| Эрсдэлийн ангилал         | Эрсдэл                    | Эрсдэлийн тодорхойлолт                                                                           | Гарах магадлал (1-5) | Хор хөнөөл (1-5) | Эрсдэлийг хянах арга хэмжээ |
|---------------------------|---------------------------|--------------------------------------------------------------------------------------------------|----------------------|------------------|-----------------------------|
| Үйл ажиллагааны эрсдэл    | Андеррайтингийн эрсдэл    | Даатгалын зүйлийг алдаатай үнэлснээс үүдэн даатгагчийн зардал даатгалын хураамжаас хэтрэх        |                      |                  |                             |
|                           | Дата мэдээллийн эрсдэл    | Даатгуулагчийн мэдээлэл, хохирлын мэдээлэл алдаатай байснаас хураамж, нөөц сан хүрэлцээгүй болох |                      |                  |                             |
| Оролцогч талуудын эрсдэл  | Давхар даатгагчийн эрсдэл | Давхар даатгалын гэрээгээр хүлээсэн хариуцлагаа биелүүлж чадахгүй байх                           |                      |                  |                             |
|                           | Даатгагчийн эрсдэл        | Даатгагч давхар даатгалын хураамжийг цаг тухайд нь төлөхгүй байх                                 |                      |                  |                             |
|                           |                           |                                                                                                  |                      |                  |                             |
| Хөрөнгө оруулалтын эрсдэл | Хүүгийн эрсдэл            | Хөрөнгө оруулалтын өгөөж төлөвлөснөөс доогуур байх                                               |                      |                  |                             |
|                           | Арилжааны банкны эрсдэл   | Хөрөнгө хадгалуулсан арилжааны банк нь эрсдэлд орох, татан буугдах                               |                      |                  |                             |
|                           |                           |                                                                                                  |                      |                  |                             |
| Санхүүгийн эрсдэл         | Инфляцын эрсдэл           | Эдийн засаг, зах зээлийн төсөөлөл бодит байдлаас зөрөх                                           |                      |                  |                             |
|                           | Валютын ханшийн эрсдэл    | Гадаад гүйлгээ хийх тохиолдолд төгрөгийн ханш унах                                               |                      |                  |                             |

|                             |                                      |                                                                                                                     |  |  |  |
|-----------------------------|--------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--|--|
|                             | Нягтлан бодох бүртгэлийн эрсдэл      | компанийн нягтлан бодох бүртгэлийг хууль, тогтоомж, стандартаас зөрүүтэй хөтлөх                                     |  |  |  |
|                             |                                      |                                                                                                                     |  |  |  |
| Мэдээлэл технологийн эрсдэл | Сервер гаднын халдлагад өртөх эрсдэл | Сервер гаднын халдлагад өртсөнөөс үүдэн хэвийн ажиллагаа тасалдах, зогсох                                           |  |  |  |
|                             |                                      |                                                                                                                     |  |  |  |
|                             |                                      |                                                                                                                     |  |  |  |
| Улс төрийн эрсдэл           | Улс төр, удирдлагын эрсдэл           | Улс төрийн тогтворгүй байдлаас хамааран удирдлага болон боловсон хүчинд өөрчлөлт орж, хэвийн үйл ажиллагаа тасалдах |  |  |  |
|                             | Хувьцаа эзэмшигчийн эрсдэл           | Улс төрийн тогтворгүй байдлаас үүдэн хувьцаа эзэмшигч буюу Сангийн яам нь төсөв багасгах, үйл ажиллагааг хязгаарлах |  |  |  |
|                             |                                      |                                                                                                                     |  |  |  |
| Хүний нөөцийн эрсдэл        | Ур чадвартай ажилтнаа алдах эрсдэл   | Мэргэжилтэн болон чадварлаг ажилтан компанийг орхисноос хэвийн үйл ажиллагаа тасалдах                               |  |  |  |
|                             | Ажилтны хариуцлагын эрсдэл           | Ажилтан ажил үүргээ биелүүлэх явцдаа санаатай болон санамсаргүйгээр алдаа гаргах                                    |  |  |  |

|                                 |                                            |                                                                                                            |  |  |  |
|---------------------------------|--------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------|--|--|--|
|                                 |                                            |                                                                                                            |  |  |  |
| Хууль эрх зүйн эрсдэл           | Эрх зүйн актыг зөрчих эрсдэл               | Компанийн үйл ажиллагаа нь эрх бүхий этгээдээс баталсан эрх зүйн актыг зөрчих эрсдэл                       |  |  |  |
|                                 |                                            |                                                                                                            |  |  |  |
|                                 |                                            |                                                                                                            |  |  |  |
| Болзошгүй хүчин зүйлсийн эрсдэл | Оффисын эрсдэл                             | Цахилгааны хэлбэлзэл, ус алдах зэргээс шалтгаалан ажлын байрны хэвийн бус байдал үүсэх                     |  |  |  |
|                                 | Байгалийн давагдашгүй хүчин зүйлийн эрсдэл | Байгалийн гамшигт үзэгдлээс шалтгаалан ажлын байрны хэвийн байдал, бизнесийн үйл ажиллагаа алдагдах эрсдэл |  |  |  |
|                                 |                                            |                                                                                                            |  |  |  |
| Нийгмийн эрсдэл                 | Халдварт өвчин                             | Халдварт өвчнөөс шалтгаалан ажлын байрны хэвийн байдал, бизнесийн үйл ажиллагаа алдагдах эрсдэл            |  |  |  |
|                                 |                                            |                                                                                                            |  |  |  |
| Нэр хүндийн эрсдэл              |                                            |                                                                                                            |  |  |  |
|                                 |                                            |                                                                                                            |  |  |  |